

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ 2 ДУГААР УЛИРАЛД БҮРТГЭЛ ХЯНАЛТАД АВСАН ЗАХИРАМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

2024 оны 08 дугаар сарын 08

Мандалговь хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Аймгийн Засаг даргын 2024 оны 2 дугаар улиралд батлан гаргасан захирамжийн хэрэгжилтийн үр дүнг үнэлэх, зөвлөмж гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, захирамжийн хэрэгжилтийн үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Аймгийн Засаг даргын 2024 оны 2 дугаар улиралд батлан гаргасан хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.3-т заасан аргачлалаар хийлээ.

Аймгийн Засаг даргаас 2024 оны 2 дугаар улиралд нийт 344 захирамжийг батлан гаргасан бөгөөд үүнээс үүрэг болгосон үр дүнг эргэн тооцох 12 захирамжийн 12 заалтыг хяналтад авч хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Төрийн захиргааны, удирдлагын хэлтэс холбогдох сум, хэлтэс, агентлагуудаас биелэлтийг гаргуулан авч нэгтгэн тайланг 2024 оны 08 дугаар сарын 08-ны өдөр эцсийн байдлаар ирүүлсэн.

ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Аймгийн Засаг даргын 2024 оны 2 дугаар улиралд хяналтад авсан 12 захирамжийн 12 заалт 93,3 хувийн хэрэгжилттэй байна. Үүнээс 100 хувь -8, 90 хувь -2, 70 хувь -2 заалт байна.

Дүнгээс харахад: Бүрэн хэрэгжсэн буюу 100 хувьтай 8 заалт нь нийт заалтын 66,6 хувийг, 90 хувьтай 2 заалт 16,6 хувийг, хэрэгжих шатандаа буюу 70 хувьтай хэрэгжиж байгаа 2 заалт нь 16,6 хувийг тус тус эзэлсэн байна.

Явцын дүнг хүснэгтээр харуулбал:

Д/д	Шийдвэрийн нэр	Заалтын тоо	Хэрэгжилтийн хувь			Хэрэгжилтийн дундаж хувь
			100	90	70	
1	Аймгийн Засаг даргын 2 дугаар улирлын захирамж	12	8	2	2	93,3

ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖИЖ БАЙГАА ОНЦЛОХ АРГА ХЭМЖЭЭНҮҮДЭЭС ДУРДВАЛ:

1. Монгол улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигаар жил бүрийн 5 дугаар сарын эхний 7 хоногийн “Ням” гаригийг “Үндэсний бичиг үсгийн баяр”-ын өдөр болгон тэмдэглэх шийдвэрийн хүрээнд Аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн А/317 дугаар “Үндэсний бичиг үсгийн баяр 2024 үйл ажиллагааг зохион байгуулах тухай” захирамжаар уг арга хэмжээг 2024 оны 5 дугаар сарын 08-17-ны өдрүүдэд зохион байгуулж 1943 хүн оролцсон байна. “Бийрийн хэлхээ-2024” 55 суралцагч, үндэсний бичгээр хурдан зөв унших чадварыг хөгжүүлэх “Тэргүүний уншигч” уралдаанд 49 суралцагч, “Төрийн албан хаагчдын их сорилго”-д 142 төрийн албан хаагчид, “Төрийн албан хаагчдын цахим бичвэр” уралдаанд 63 төрийн албан хаагчид, “Үндэсний бичгийн тээгч, түгээгч” арга хэмжээнд 9 сумын нийт 18 иргэд тус тус амжилттай оролцсон. Энэхүү арга хэмжээнд 7.5 сая төгрөг зарцуулсан байна.



2. Зууны Манлай Алдарт уртын дуучин МУГЖ Ж.Дорждагвын нэрэмжит Дуртмал сайхан өсвөрийн уртын дуучдын уралдааныг 05 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд зохион байгуулсан байна. Уртын дууны уралдаанд 5 аймгийн 12 сумын төлөөлөл нийт 65 хүүхэд оролцож давхардсан тоогоор 110 бүтээл дуулагдсанаас 2 насны ангилалд шалгаруулж 8 шилдэг шалгарч, морин хуурын эхний 3 байрыг шагнаж нийт 15 хүүхдийг шагнаж урамшуулсан. Орон нутгийн төсвөөс 17 сая төгрөгийг зарцуулсан.



3. Олон улсын гэр бүлийн өдөр, хүүхдийн баярын өдрийг тохиолдуулан Миний гэр бүлийн баяр хөөр нөлөөллийн үйл ажиллагааг 05 дугаар сарын 15-ны өдрөөс 06 дугаар сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулсан байна. “Хайр дүүрэн гэр бүл” өдөрлөгийг Сайнцагаан сумын хэмжээнд зохион байгуулж, өдөрлөгөөр “Гэр бүл дэх хүүхэд хамгаалал, үр бүтээмжтэй цаг” сэдэвт сургалтыг зохион байгуулан сургалтын үйл ажиллагаанд 34 байгууллагын 250 гаруй төрийн албан хаагч, иргэд хамрагдсан байна. Улсын төсвөөс 9.7 сая төгрөгийг зарцуулсан.



ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Аймгийн Засаг даргын баталсан захирамжийн хэрэгжилтийн явцад улирал бүр хяналт шинжилгээ, үнэлгээг хийж холбогдох хэлтэс, байгууллагуудад зөвлөмж өгч үр дүнг тооцон ажиллаж байна.

1 дүгээр улиралд 5 зөвлөмж өгч үр дүнг тооцон ажилласан бөгөөд зөвлөмжийн хэрэгжилтийн дундаж 100 хувьтай хэрэгжсэн байна.

Цаашид өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих шаардлагатай байна.

2024 оны 2 дугаар улиралд Аймгийн Засаг даргаас батлан гаргасан захирамжийн хэрэгжилт 93,3 хувьтай хэрэгжиж, өмнөх оны мөн үеэс 2 хувиар өссөн байна.


Хоёрдугаар улиралд батлан гаргасан 344 захирамжаас үүрэг болгосон үр дүнг эргэн тооцох 12 захирамжийг хяналтад авч биелэлтийг гаргуулахад бүгд нэг удаагийн шинжтэй байгаа бөгөөд 12 заалтаар үүрэг өгөгдсөний 8 заалт нь 100% хэрэгжиж 2 заалт 90 хувь, 2 заалт 70 хувьтай байна.

Хэрэгжих шатандаа буюу 70 хувьтай хэрэгжиж байгаа 2 заалт нь цаг хугацааны хувьд удаашралттай байгаа бөгөөд гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургууль, бэлэн байдлын үзлэгийг 3 дугаар улиралд зохион байгуулахаар бэлтгэл ажил хийгдэж байна.

Мөн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үзлэгийг 5 суманд зохион байгуулахаар төлөвлөсөн ч одоогоор 4 суманд зохион байгуулаад байна. Сайнцагаан суманд барилгын салбарт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үзлэгийг зохион байгуулж байна.

2024 оны 2-р улирлын байдлаар нийт 12 захирамжийн 12 заалтаас 5 заалтын хэрэгжилтийг ХБТХОХ болон харьяа хэлтэс, агентлагуудад хамааралтай гаргаж хэрэгжилтийн дундаж 96,0 хувьтай байна. НБХ болон харьяа хэлтэс, агентлагуудад хамааралтай 4 заалтын хэрэгжилтийн дундаж 92,5 хувь, ТЗУХ болон харьяа хэлтсүүдэд хамааралтай 3 заалт 90 хувийн биелэлттэй байна.

Захирамжийн тоо болон хэрэгжилтийн хувийг графикаар харуулбал:



ТАВ. ЗӨВЛӨМЖ

1. Гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургууль, бэлэн байдлын үзлэгийг 3 дугаар улиралд чанартай зохион байгуулж үр дүнг танилцуулах.

/Онцгой байдлын газарт/

2. Сайнцагаан сум, барилгын салбарт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үзлэгийг хугацаанд нь зохион байгуулан тайлагнах. **/ Нийгмийн бодлогын хэлтэст /**

3. Зарцуулсан хөрөнгийн хэмжээг заавал гаргаж ирүүлэх **/Төрийн захиргааны удирдлагын хэлтэст/**

4. Цаашид нотлох баримтын хамт ирүүлж байх **/Төрийн захиргааны удирдлагын хэлтэст/**

5. Захирамжийн хэрэгжилтийг бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны биелэлтийг 2024 онд тайлагнах хуваарийн дагуу хугацаанд нь зөвлөмжийн хамт гарган ирүүлэх **/Төрийн захиргааны удирдлагын хэлтэст/**

Бодлогын хэлтсүүд өгсөн зөвлөмжийг холбогдох хэлтэс, агентлагууддаа хүргүүлэн хэрэгжилтэд нь хяналт тавин тайланг 3 дугаар улирлын захирамжийн хэрэгжилтийн хамт ирүүлэх

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС